

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 01

Өлгий хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 16:30 цагаас компанийн хурлын зааланд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

2.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

2.2. Компанийн 2025 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах;

2.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэр дэвшүүлэх;

2.4. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийн талаарх ТУЗ-ийн мэдээллийг хэлэлцэж батлах;

2.5. ТУЗ-ийн зардлыг нэмэгдүүлэх;

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай.

Комиссын даргаар: Компанийн Гүйцэтгэх захирал М.Тилеуберди, гишүүдэд: ТУЗ-ийн гишүүд А.Бейбит, Харашаш.

4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:

4.1. Ээлжит хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 2026 оны 03-р сарын 21-ний өдрийн дотор олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, хөрөнгийн биржийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авах.

4.2. Энэ тогтоолын 4.1-д заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар

нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх.

4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2026 оны 03 дугаар сарын 21-ны дотор хүргүүлэх.

4.4. Хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх “Таван богд ҮЦК” ХХК-тай гэрээ байгуулж, уг гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах;

4.5. Хувцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал тэдгээрийн танилцуулга, гарах шийдвэрийн төсөл, санал авах, хуудсыг үнэт цаасны брокер дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2026 оны 3 дугаар сарын 23-ний дотор багтаан хүргүүлэх;

4.6. Хурлаас хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийг дуустал 09-13, 14-17 цагт компанийн хурлын зааланд танилцуулж саналын хуудсаар санал авах ажлыг зохион байгуулах.

5. Хурал зарласан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд дор дурьдсан баримт бичгийг танилцуулахыг хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

5.1. Компанийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл

5.2. Санхүүгийн жилийн тайлангийн талаар Аудиторын дүгнэлт

5.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн тухай танилцуулага

5.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тогтмол цалинтай болгох тухай

5.5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох бусад мэдээлэл

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.

7. Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 08-ний өдрөөр тогтоосугай.

8. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга А.Маненийг сонгосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар О.Адилбек, гишүүнээр Ш.Майраш, Ж.Серикжан нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.МАНЕН